

АГУУЛГА

1.1.	Төслийн товч тодорхойлолт	3
2.	ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	7
	ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ	13
	БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	13
3.1.	Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ	13
3.2.	Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	13
3.3.	Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	13
3.4.	Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	13
7.	ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	19
8.	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
9.	ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
10.	ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
11.	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
12.	ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
12.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	25
12.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
13.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГЫН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ	29

Хавсралт материал

- Хяналтын хуудас
- Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар
- Үнэлгээний батлагдсан нүүр
- Ерөнхий үнэлгээний дүгнэлт
- Гол усны лавлагаа
- Дэвсгэр зураг
- CD

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол	3
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	18
Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах ажил, тэр бум мод	19
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
Хүснэгт 8. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	28
Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	29
Хүснэгт 10. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт	30

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Юбиксолюшн” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011487101

Төслийн нэр: “Цагаан чулуут хоолойн доод (ХШ-42-ХШ-50-ын хооронд)” хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл


Төслийн байршил:

Гүн-Өндөр-2 талбай Дорнод аймгийн Баяндун сумын нутаг дэвсгэрт, газарзүйн байрлалын хувьд 1:200 000 масштабтай зургийн М-49-XXIV, 1:100,000 масштабтай М-49-95 зураг дээр, Улаанбаатар хотоос 700 км Баяндун сумаас 25 зайд байрлана.

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол

№	Уртгаг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	113	28	43.94	49	25	21.91
2	113	28	43.94	49	26	37.11
3	113	27	2.43	49	26	37.11
4	113	27	2.43	49	25	21.91
5	113	28	43.94	49	25	21.91

Тусгай зөвшөөрлийн талбайн байршлын тойм зураг



Зураг 1. Талбайн байршлын тойм зураг

2026 оны уулын ажлын төлөвлөгөө

Уурхайн бэлтгэл ажил 2026 оны 03-р сарын 1-ээс эхлэх бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зарим шаардлагатай засвар үйлчилгээний ажлууд хийгдэнэ.

Тухайн жилд ашиглах блокуудын шимт хөрсийг ялган бульдозероор түрж блокын хилийн гадна шимт хөрсний овоолгод байршуулж үндсэн хөрсийг экскаватор, автосамосвал ашиглан гадаад болон дотоод овоолгод шилжүүлэн байршуулахаар төлөвлөв.

Ашиглалтын эхний жил 1-С, 2-В, 3-В гэсэн блокуудыг олборлохоор төлөвлөсөн. Уурхайн урт 620 м, өргөн 230 м, 12.11 га талбайг эзэлж байна. Эхний жилд дээрх блокуудаас нийт 2808.86 мян.м³ хөрс хуулж, дунджаар 484 мг/м³ агуулгатай 127.3 мян.м³ элс олборлон баяжуулж 50.22 кг алт /химийн цэврээр/ гарган борлуулахаар байна.

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Уулын ажлын жилийн хүчин чадал, ордыг ашиглах хугацаатай уялдуулж дараах календарчилсан төлөвлөгөөг тооцоолов. Ашиглалтын эхний жилд 2808.86 мян.м³ хөрс хуулж, 127.3 мян.м³ алттай элс олборлон баяжуулахаар төлөвлөв. Хөрс хуулалтын коэффициент дунджаар 22.47 м³/м³ байна.

Ашиглалтын эхний жил уурхайгаас нийт 2936.16 мян.м³ уулын цул хөдөлгөх бөгөөд дунджаар 484.04 мг/м³ агуулгатай 127.3 мян.м³ элс олборлон баяжуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт 2. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2026 онд			Нийт
			П-р улирал	Ш-р улирал	ГУ-р улирал	
1	Уулын цул	мян м ³	670.3	1450.5	813.03	2936.16
2	Нийт хөрс хуулалт:		636.2	1365	807.62	2808.86
	Үржил шимт хөрс хуулалт	мян м ³	20.3	16.03		36.33
	Хөрс хуулалт	мян м ³	694	1247	831.49	2772.49
3	Элс олборлолт	мян м ³	31.2	56.5	37.31	127.3
4	Хөрс хуулалтын коэффициент	м ³ /м ³	22.25	21.7	22.12	22.47
5	Угаах элсний хэмжээ	мян м ³	31.2	56.5	37.31	127.3
6	Дундаж агуулга	мг/м ³	472.3	488.4	485.9	484.04
8	Металлын хэмжээ /химийн цэврээр/	кг	15.2	27.5	17.81	60.51
9	Металл авалт	%	83	83	83	83
11	Металлын хэмжээ /химийн цэврээр/	кг	12.62	22.82	14.78	50.22

Үржил шимт хөрс хуулалт. Үржил шимт хөрсийг хуулахдаа ашиглалтын тухайн жил бүрийн эхэнд хайгуулын шугамын дагуу зүүн хойноос баруун урд зүгт бульдозероор 0.3 м-ийн зузаанаар хуулан түрж, уурхайн баруун урд ирмэг дагуу овоолно.

Үржил шимт хөрсний овоолгыг 3 м-ээс ихгүй өндрөөр байгуулж, ашиглалтын явцад дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлыг уулын ажилтай зэрэг гүйцэтгэх боломжтой байхаар төлөвлөв. Шимт хөрсний овоолгын өндөр 3 м, сул чөлөөтэй, ямар ч нягтаршуулалгүй, овоолгын гадаргуу дээгүүр автосамосвал, бульдозер гэх мэт хүнд даацын тоног төхөөрөмж явахгүй байх шаардлагыг баримтална.

Хөрс хуулалтын ажил. Нээлтийн ажлын дараа 2-В блокийн хөрсний чулуулгийг экскаватор-автосамосвалын хослолоор хуулан тээвэрлэж 1-С блокийн олборлосон хэсэгт дотоод овоолго байгуулах байдлаар цаашид хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөв.

Хөрс хуулалтын ажлын догол мөргөцгийн өндөр нь ажиллах тоног төхөөрөмжийн үзүүлэлт, хөрсний доголын зузаанаас хамааран 5-10 м байна.

Элс олборлолтын технологи. Элсний давхарга нээгдмэгц элс олборлолтын ажлыг экскаватор-автосамосвалын хослолоор гүйцэтгэнэ. Элс олборлолтын доголын өндөр нь элсний давхаргын зузаанаас хамаарах бөгөөд дунджаар 1.5-2.1 м байна.

Усан хангамж

Технологид шаардлагатай усны хэмжээ. Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор уурхайн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглана. Алт олборлож байгаа уурхайнуудын туршлага, үүсмэл нуурын шүүрэлт, усны ууршилт, алдагдал, ордын талбайтай зэргэлдээ олборлолт явуулж байгаа ордын нууруудын шүүрэлт зэргийг үндэслэн шаардагдах усны 30%-ийг цэвэр усаар сэлбэх ба 70%-ийг технологийн эргэлтийн усаар хангах боломжтой байна. Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай учир 1 м³ элс угаахад 2.11 м³ ус хэрэглэхээр тооцоолов.

Хүснэгт 3. Угаах процесст зарцуулагдах усны хэрэгцээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2026 онд			Нийт уулын ажлын хэмжээ
			П-р улирал	Ш-р улирал	ГУ-р улирал	
1	Угаах элсний хэмжээ	3 мян.м	33.49	56.5	37.31	127.3
2	1м ³ элс угаахад зарцуулах усны хэмжээ	м ³	4	4	4	4
3	Технологит зарцуулах нийт ус.хэм	3 мян.м	125	225	150.04	500.04
	Цэвэр усны хэмжээ 30%	3 мян.м	37.8	67.5	44.71	150.01
	Эргэлтийн усны хэмжээ 70%	3 мян.м	87.5	157.5	105	350.0

Хүснэгтээс үзэхэд угаах процесст зарцуулах цэвэр усны хэмжээ 2026 онд 10.533 мян.м³ байна. Нийт зарцуулагдах усны 85%-ийг эргэлтэнд оруулж 15%-ийг цэвэр усаар сэлбэнэ. Технологийн усыг эргэлтийн усан санд хуримтлуулан тунгааж, процесст эргүүлэн хэрэглэнэ.

Унд ахуйн усны хэрэглээ. Уурхай нь улирлын чанартай ажиллах ба уурхайн хотхонд байнга 78 хүн ажиллаж амьдарна. Оршин суугч нэг хүний хоногийн усны хэрэглээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтаар нэг ажилчны ээлжинд буюу ажлын байранд хэрэглэх халуун болон хүйтэн усны хэрэглээ 20-200л/хон байна. Хоногт зарцуулагдах хэрэглээний усны 1 хүнд оногдох хэмжээ дунджаар 150 л гэж үзвэл, нийт хэмжээ 7650 л буюу 7.6 м³/хон (0.09 л/сек) болно. Унд ахуйн усны хэрэгцээг хотхонд гаргасан гүний худгаас хангахаар төлөвлөв.

Хүснэгт 4. Уурхайн нийт усны хэрэглээ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2026 онд
1	Технологийн замын тоосжилт дарах	м ³ /жил	5017
2	Баяжуулах үйлдвэрт	м ³ /жил	150013
3	Унд ахуйд	м ³ /жил	1680
4	Байгаль орчин нөхөн сэргээлт	м ³ /жил	800
	Нийт	м ³ /жил	157510

Барилга байгууламж

Уурхайн гадаргуугийн ерөнхий төлөвлөгөөнд уурхай, үржил шимт хөрсний овоолго, уурхайн хотхон, засварын газар, угаах төхөөрөмж, цэвэр бохир нуурын байрлал, авто зам зэрэг барилга байгууламж орно. Уурхайн хотхон, баяжуулах хэсгийн талбай, дотоод тээврийн авто замыг уурхайтай ердийн замаар холбоно.

Хүснэгт 5. Уурхайн барилга байгууламжуудын байршил, эзлэх талбай

№	Эдэлбэр газрын нэр	Талбайн хэмжээ, га	Уурхайгаас алслагдсан зай, м
1	Уурхай	12.11	
2	Үржил шимт хөрсний овоолго 1	1.5	Баруун урд ирмэг дагуу
3	Хөрсний гадаад овоолго	2.82	70м /Уурхайн зүүн талд/
4	Хотхон, засварын талбай	2.81	660 м /У урхайн баруун хойд талд/
5	Баяжуулах хэсэг /усан сан, угаан баяжуулах хэсэг/	5.8	560 м /Уурхайн баруун талд/
6	Авто зам	2	
	Нийт дүн	27.04	

Уурхайн нийт эдэлбэр газарт 2026 оны эцсийн байдлаар 27.04 га талбай хамрагдах ба ил уурхайн 12.11 га талбай олборлолтод өртөх бөгөөд үүнээс 5 га талбайд дотоод овоолгоор ашиглалтын ажилтай зэрэгцэн техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уур амьсгал


Энэ нутагт жилдээ 2936 цаг нар гийгүүлэх бөгөөд энэ ойролцоо өргөрөгт орших Улаанбаатараас 200 шахам цагаар их юм. Нар гийгүүлэх цагийн сарын нийлбэр нарны өндрөөс хамаарч 12 дугаар сард хамгийн бага-170 цаг, 5 дугаар сард хамгийн их -297 цаг байна. Энэ үзүүлэлт нарны өндөр хамгийн их байдаг 6 дугаар сард гарахгүй байгаа нь 6, 7 дугаар сард манай оронд үүлшил ихсэхтэй холбоотой юм.

Нутгийн агаарын жилийн дундаж температур -2 0 -0 °C. Хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 110-130 өдөр бөгөөд агаарын хоногийн дундаж температур + 100C ба түүнээс дээш байх өдрийн тоо 110-130 өдөр байна

Нутгийн ихэнх хэсгээр агаарын дундаж температур 0°C - 30 °C хүрч байгаа нь зургаас харагдаж байна. Хамгийн их градустай нь I сар -25°C, бага градустай нь III сар -5 °C хүрч байдаг байна.

Хүснэгт 6. Агаарын температур 2024.01-2024.12

Статистик үзүүлэлт	2024-01	2024-02	2024-03	2024-04	2024-05	2024-06	2024-07	2024-08	2024-09	2024-10	2024-11	2024-12
Агаарын дундаж температур	-19.4	-19	-7.1	6.8	13.9	20	23.2	21.1	13.3	3.2	-5.3	-13.5
Үнэмлэхүй их температур	-7.3	-1.4	8.6	24.1	31.5	36.4	35.8	33.1	30.6	23.1	8.8	-1.3
Үнэмлэхүй бага температур	-33.3	-30.7	-24.9	-7.3	0.7	7.8	13.9	10.8	-3.3	-10.5	-21	-21.5



Зураг 2. Агаарын дундаж температур

Газрын гадарга

Ашигт малтмалын хайгуулын (MV-021971) тоот тусгай зөвшөөрөлтэй Гүн-Өндөр-2 талбайн, физик газарзүйн мужлалаар Дорнод Монголын тал нутгийн тал хээрийн мужлалд багтах ба Эрээндавааны салбар Халчир Өндөр уул (1199 м), Жаргалант, Хар тогоо (1007 м), Зүүн чулуут (1049.9 м), Шар тогоо-Овоо (1055,7 м) уулсын усны хагалбар өндөрлөгүүд байрлана. Эдгээр өндөрлөгөөс эх авч урссан Цагаан чулуут худаг, Цагаан чулуут хоолой бусад зэрэгцээ хөндий, алтны бүлэг орд, илрэл агуулна.

Цагаан чулуут хоолойн Гүн-Өндөр-2 хэсэг 20 км орчим сунаж үргэлжлэх Цагаан чулуут хоолойн Улз голын хөндийтэй нийлж урсах цутгал хэсэгт, Улз голоос 2,5-3,0 км зайтай байрлана. Зэрэгцээ байрлах Ухаа Шар уулын Өвөр хөндий Ухаа Шар уулаас эх авч урсана.




Зураг 3. Төслийн талбай орчмын газрын гадарга

Хөрсөн бүрхэвч

Тус талбай нь Монгол орны нугажуу хээрийн бүсд байрлана. Гадаргын өндөршлийн хувьд далайн түвшнээс дээш 770-1100 метр орчимд хэлбэлзэх бөгөөд Ухаа шар уул, Өвөлжөөт хяр, Хуц толгой, Гол толгой зэрэг өндөрлөг газрууд, Цагаан Чулуутын хоолой, Тасагийн тал, Өндөр булагийн хөндий, Улз голын хөндий зэрэг томоохон хотос, хөндий байна. Тус талбай нь Монгол орны Физик-Газарзүйн мужлалтаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн мужийн Хэнтийн захын тойрогт багтана. Харин Хөрс-Газарзүйн мужлалтаар Хангайн их мужийн Өндрийн бүсшилтэй нутгийн Хэнтийн мужийн Хэнтийн зүүн 40-р тойрогт багтаж байна. “ЮбикСолюшн” ХХК-ий төслийн талбайд дараах хөрсний хэв шинж тархаж байна.



Дорнод аймгийн Баяндун сумын нутагт байрлах төслийн талбайн Монгол орны ургамал газарзүйн тойргоор монгол дагуурын тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Ургамалжлын хувьд Монгол Дагуурын ойт хээрийн болон хээрийн бүлгэмдэлтэй бөгөөд нам уулс, өндөрлөг толгодын ар хажуугийн дээд хэсгээр нугажуу хээрийн улалж-алаг өвс-үетэнт бүлгэмдэл бүхий сөөгөн ширэнгэ тохиолдоно. Хэнтийн тайгын өмнөд зах боловч тайгын ойгүй, алаг өвст, улалжийн сөөгт, шинэсэн, хус- шинэсэн ой, шинэс – хусан тайгархаг ой тохиолдоно. Ойн бүслүүрт голуудын эх, нарийн аманд торлог элбэг тохиолддог. Монгол оронд хязгаардтал тархалттай байдаг нугын хээрийн сөөгөн боролзгонот,. алаг өвст, зогдор улалжит, зүр өвст, байгалийн хялганат зэрэг нугын хээрийн бүх хэвслүүд байдаг.



Зураг 5. Талбайн ургамалжилтын ангилал

Дэд бүтэц: Зам харилцааны хувьд тус район нь ажил явуулах нөхцөл сайтайд тооцогдоно. Чойбалсан-Эрдэс-Ульханы сайжруулсан шороон зам тус ордын урдуур 8.5 км зайтай өнгөрдөг. Ордоос Чойбалсан хот 240 км, Баяндун сум 30 км, Дашбалбар сум 80 км, Баян уул сум 70 км, Улаанбаатар хот 700 км зайтай.

Мөн Адуун чулууны нүүрсний уурхай 240 км зайтай ба Баяндун сум АН - 2 онгоцны буудалтай. Сумын төвд соёлын төв, хүнсний жижиг үйлдвэр, сумын хүний болон мал эмнэлгийн салбар, 10 жилийн дунд сургууль, АТС холбооны станц, (үүрэн телефон мобиком, юнител чөлөөтэй холбогдоно) шатахуун түгээх станц ажилладаг.

Баяндун сумын хүн амын ихэнх нь буриад бөгөөд бусад аймаг сумуудаас нүүдэллэн ирсэн халх, үзэмчин барга бусад ястнууд амьдарч байна. Энэ нутгийн ард түмэн нүүдлийн мал аж ахуй голлон эрхлэхээс гадна хүнсний төрөл бүрийн ногоо бага хэмжээгээр тариалдаг. Сум нь дөрвөн багтай баг бүр нь өөрийн төвүүдтэй, сум ба багийн төвүүд дээр амьдардаг хүмүүс нь улсын байгууллага, хоршоолол, компаниудад ажиллах буюу хувиараа ажил хөдөлмөр эрхэлдэг байна.

3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1.Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ

2026 онд уулын ажлын хөрс хуулалт, олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

3.2.Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

3.3.Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2026 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Ил уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэнэ. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

3.4.Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

3.5.Нөхөн сэргээж буй газрыг хүн мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхайн эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж дууссан газрыг бусад хүчин зүйлээс болж буцаж эвдэрч, доройтохоос хамгаалахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. Хүн малын нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Биологийн нөхөн сэргээлт хийсэн газарт мал орох, болон санаатайгаар малаа хариулах, тарьсан мод, бутыг хэрэглэх, машин техникээр дээгүүр нь явах, ахуйн зорилгоор ухаж сэндийлэх зэрэг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд энд орон нутгийн захиргаа болон нутгийн иргэдийн ухамсарт оролцоо маш чухал үүрэгтэй байна.

2. Усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Нөхөн сэргээлт хийсэн газар нь хэвгий, налуу ихтэй хөрсний бүтэц султай болон бүтэцгүй тохиолдолд хөрс усаар угаагдаж, алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Ийм газарт ургамлын тарих эгнээг налуугийн эсрэг чиглэлд хийх, шигүү тарих, сахлаг үндэстэй ургамал тарих зэрэг арга хэмжээг авна.

3. Салхины нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхай орчмын нутаг нь хуурай хээрийн бүсэд хамаарах газар учраас жилд тохиолдох хүчтэй салхи шуурганы давтамж өндөр байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийсэн

газрыг салхины эвдрэл болон элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээг зайлшгүй шаардлагатай. Энд салхины зонхилох чиглэлд хөндлөн байдлаар бут сөөг модлог ургамал оролцсон зурвас байгуулах, төрөл бүрийн механик хамгаалалт хийх шаардлагатай.

Байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж

Сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг тогтмол хийж, хяналт тавих. Стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авах.
- Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах.
- Тоосжилт тархах хүрээ ачиж, тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчимд байхаар зам, овоолгын байршлыг оновчтой сонгох, улмаар байнгын ажлын байрнаас зайдуу байршуулах хэрэгтэй.
- Уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замуудыг байнга усалж байх, ялангуяа тоосжилт, шороон шуурганы гаралт нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд төслийн талбайг усаар норгох, чийглэх
- Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, хөрс тээвэрлэсэн автомашиныг хучиж, хөрс, тоос салхинд хийсэж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх.
- Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэх.
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх
- Ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтсон нэг маршрутын дагуу явуулах, МУ-ын стандартын дагуу замын уулзвар, салаалалт дээр тэмдэгжүүлэх
- Үржил шимт өнгөн хөрсийг хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулах
- Уурхайн үйл ажиллагааны явцад боломжтой газруудад нөхөн сэргээлтийг дор дор нь хийж байх
- Ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах
- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авах
- Тоног төхөөрөмжийн шатах тослох материал болон барилгын материалын Төвлөрсөн цэгийг байгуулж, нэвчүүлэхгүй материал ашиглан тохижуулах
- Шатах тослох материал, алдагдах, асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Уурхайн дотоод, гадаад тээврийн үйл ажиллагаанаас үүсэх орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг ашиглахаас аль болох зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах
- Тоосны ялгаралтыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгахын тулд байнгын хяналттай ажиллах зэрэг арга хэмжээг авч ажиллана

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь “Юбиксоллюшн” ХХК-ийн “Цагаан чулуут хоолойн доод (ХШ-42-ХШ-50-ын хооронд)” хэсгийн алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино. Энэ хүрээнд

Тус төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг тусгасан сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ зэргийг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Мөн тус төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус тус боловсруулсан болно.

Тус төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу батлагдсан аргачлалыг баримтлан боловсруулсан бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно. Харин нөхөн сэргээлтийн төлөвлөгөө болон хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг тус тус оруулсан болно. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь

зэрэг

ажлууд

багтсан

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаарын чанар					
Уурхайн олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх	Уурхайн олборлолт, хөрсний овоолго үүсгэх, түр шороон замаар тээвэрлэлт хийх үед усалгаа хийх, хөрс барьцалдуулагч шингэнээр шүрших	Уурхайн ухаш, хөрсний овоолго, зам	3.0	4-9 сард салхи, хуурайшилт ихтэй өдрүүдэд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2025 - MNS 3384:82
Уулын ажлаас тоос босож орчны агаарын чанарыг муутгаад зогсохгүй уурхайд ажиллаж буй ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө	Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх	Уурхайн бүх авто машинуудад	2.0	Автомашин үзлэгт орох үед	MNS 4885:2007
Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг хянах	Агаарын хяналт шинжилгээг тогтмол хийх	Төслийн нөлөөллийн талбайд	Зардал нь ОХШХ-ийн зардалд орсон	8-р сард	Агаарын тухай хууль
Нийт зардал			5.0		
Ус					
	Ундны усны эрүүл ахуйн бүс тогтоож, тоолууржуулах	1	2.5	Ундны усаа хангаж буй гүний худагт тогтмол шинжилгээ хийлгэж байх, цэвэршүүлэн ашиглаж байх	
Нийт зардал			2.5		

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших MV-021971 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Цагаан чулуут хоолойн доод (ХШ-42-ХШ-50-ын хооронд)” хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

2026 он

Амьтан					
Төслийн үйл ажиллагаанаас амьтдын амьдрах орчныг удаан хугацаагаар хомсдуулах зэргээр сөрөг нөлөө үзүүлнэ	Орд орчмын амьтны зүйлийн бүрдэл, тархац	Төслийн талбай түүний ойролцоо	Зардал нь ОХШХ-ийн зардалд орсон	2026	- Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай
Нийт зардал			-		
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг					
Хөрс хуулах, элс олборлох, овоолго байгуулах явцад ургамал талхлагдан хөрс эвдрэлд орж, газрын тогтоц, хэлбэр, төрх өөрчлөгдөж, ухагдаж эвдэрнэ.	Хог хаях, шатах тослох материал асгах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Бүх жолооч нарт	1.5	Жилд 1 удаа	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2023
	Автомашинь зогсоолыг цементэн хучилттай болгох	Бүх зогсоол	1.5	2026	
Олон салаа зам гарснаас хөрсөн бүрхэвчийн элэгдэл, эвдрэлийн эрчим нэмэгдэнэ.	Уурхайн дотоод болон гадаад тээврийн замын дагуу шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Осол аваар гарч болзошгүй цэгүүд	1.0	Жил бүр	
Биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүн шимт хөрсний чанараас хамаарна. Шимт хөрсний чанар муу байх нь нөхөн сэргээлтийн ажлыг үр дүнгүй болгож экосистемд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.	Шимт хөрсний нөөц бий болгох стандартын дагуу овоолж, ургамалжуулан хадгалах	0.5 мян.м3 шимт хөрс	2.0	2026-2027	MNS 5916:2008
Нийт зардал			5.0		
Нийт зардал, сая.төг			12.5		

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн нөхөн сэргээлт

2026 онд 2.5 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийх бөгөөд тус онд биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй.

Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7
1.	Техникийн нөхөн сэргээлт	га	2.5	-	Уулын ажлын зардал д багтсан	2026 онд	MNS 5914:2008 MNS 5918:2008 MNS 4919:2000 MNS 4920:2000
	Нийт	-					

6. ТЭР БУМ МОДНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. ТЭР БУМ МОДНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
	1	2	3	4	5	6
1.	Сум орон нутгийн саналын дагуу сумын нутаг дэвсгэрт 200 мод тарихаар төлөвлөв.	ш	200	-	2000000	“Тэр бум мод” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд
	Нийт	2000000				

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

“ЮБИКСОЛЮШН” ХХК нь 2026 онд Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Аймаг орон нутгийн саналын дагуу Тарвага сэргээн нутагшуулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэнэ

Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах ажил, тэр бум мод

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	2026 онд Аймаг орон нутгийн саналын дагуу Дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөв.	Тарвага сэргээн нутагшуулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэнэ/Гэрээг хавсаргав/	Сумын нутаг дэвсгэрт	-	10000000	10000000	2026 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
	Нийт					10000000		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“ЮБИКСОЛЮШН” ХХК-ийн MV-021971 тоот талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Баяндун сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Болзошгүй зардал 500000 төг төсөвлөсөн.

10. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хүснэгт 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	
Хог хаягдлаар хөрс бохирдох	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	0.5	Жил бүр	Хог хаягдлын тухай хууль 4-р зүйл, 5-р зүйл 9-р зүйл, 11-р зүйл, 12-р зүйл, 13-р зүйл, 14-р зүйл, 16-р зүйл, 18-р зүйл, 19-р зүйл, 20-р зүйл, 21 -р зүйл, 23-р зүйл, 24-р зүйл
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж түр хадгалах зориулалтын хогийн бункер байрлуулах	-	Тухай бүрд нь	
Хог хаягдал бороо, цасны усаар доошоо нэвчиж хөрс, газрын доорх усыг бохирдуулж болзошгүй	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	1.2	2024	
Төслийн үйл ажиллагаанаас үүсэх ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаар хөрс, гадаргын болон газрын доорх ус бохирдуулах сөрөг нөлөөтэй	Хуванцар сав, шил, лааз гэх мэт хаягдлыг сумын төвд 2-догч түүхий эд авах цэгт тушаах	-	Сард 1 удаа	
	Дугуй, модны хаягдлыг дахин ашиглах, орон нутгийн хэрэгцээнд өгөх	-	Тухай бүрд нь	
	Автомашинны сэлбэг, төмрийн хаягдлыг мэргэжлийн байгууллагад гэрээний дагуу нийлүүлэх	-	Жилд 2 удаа	
	Цаас, цаасны хаягдлыг цаас боловсруулах үйлдвэрт тушаах	-	Жилд 2 удаа	
	Гал тогооноос гарсан хоол, хүнсний хаягдлыг бордоо болгох	-	7 хоногт 1 удаа	
	Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах	2.0	Тухай бүрд нь	
	Боломжтой хог хаягдлыг дахин ашиглах	-	Тухай бүрд нь	
Шатах тослох материалаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй	Ажилласан тос, тосолгооны материалыг битүүмжлэл сайтай саванд хуримтлуулах	-	Жилд 2 удаа	
Ахуйн бохир шингэнээр хөрс бохирдоно	Ахуйн бохир шингэн хаягдлыг битүүмжлэл сайтай ёмкост хуримтлуулан бохир соруулах машинаар холбогдох газарт нийлүүлэх	-	Бохирын цооногийн 70% дүүрсэн тохиолдолд	

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших MV-021971 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Цагаан чулуут хоолойн доод (ХШ-42-ХШ-50-ын хооронд)” хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

2026 он

	Бохир ус хуримтлуулах сав буюу ёмкосыг нэвчилт шүүрэлт явагдахааргүй битүүмжлэл сайтай хийх	2.0		
	Бохир ус хуримтлуулах сав буюу ёмкосын бүрэн бүтэн байдал, нэвчилт шүүрэлт явагдаж байгаа эсэхэд байнгын мониторинг хийх /Бохир ус хуримтлуулах савны 70% дүүрмэгц соруулах нь зүйтэй/	1.0		
Аюултай хог хаягдлын хадгалалтын горим алдагдсанаас орчны хөрс, ус, агаарыг бохирдуулах	Аюултай хог хаягдлын Хог хаягдлын тухай хуульд заасан хугацаанаас илүү хугацаагаар хадгалах нөхцөлд холбогдох газраас зөвшөөрөл авах	-	Тухай бүрд	
Аюултай хог хаягдлаар хөрс, ус, агаар бохирдох, улмаар хүн амьтын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан эдгээр үйл ажиллагааг гүйцэтгэх.	-	Тухай бүрд нь	
Бохирдсон зүү тариур, боолтоор халдвар дамжих, тархах	Эмнэлгийн хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	Гэрээ байгуулах	Улиралд 1 удаа	
Ажилчид санаатай болон санамсаргүйгээр ил задгай хог хаях	Уурхайн ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилан ялгах, боломжтойг дахин ашиглах талаар сургалт явуулах	-	Жилд 1 удаа	
Бусад	Үлдэгдэл хог хаягдлыг эцэслэн зайлуулахдаа сумын ТҮК-тай гэрээ байгуулан зайлуулах	1.0	Жил бүр	
Нэг жилийн зардал, сая.төг		7.7		

12. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БАЙГАЛИЙН АЮУЛ, ГАМШИГ

Аянга цахилгаан: Дулааны улиралд тохиолдох бөгөөд цаг агаарын мэдээг тогтмол мэдээлэх хэрэгтэй. Цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, ил задгай цахилгааны утас зэрэг аянга үүсэж болзошгүй зүйлүүдийг хамгаалах

Газар хөдлөлт: Газар хөдлөлтийн мужлалаар төсөл хэрэгжих газар нь 6 баллын бүсэд хамаарна. Иймээс барилга байгууламж барихдаа зураг төслийн дагуу эрсдэлийг нарийвчлан авч үзэх шаардлагатай. Мөн ашиглалтын явцад газар хөдлөлтийн үед авах арга хэмжээг боловсруулах. Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бий болгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх.

Шороон шуурга: Салхины хурдыг багасгах хаах тоос шороог багасгах зорилгоор салхины зонхилох чиглэлд ногоон байгууламжуудыг бий болгох. Уурхайн замыг тогтмол арчилж, усалгаа хийж чийгшүүлж байх. Ажлын байрны эрүүл ахуйн хяналтыг системийг бий болгох. Онц байдалд үйл ажиллагааг зогсоох тухай журам боловсруулж мөрдөх Халдварт өвчин: Уурхайн ажилчдад хууль бус ан агнахгүй байх түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөллийн талаар сургалт явуулах, хамгаалалтын хэрэгслээр хангах (амны хаалт г.м), аймгийн эрүүл мэндийн төвтэй харилцаа холбоотой байж мэдээлэл авч байх

Гал түймэр: Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, зааварчилгаа, хяналтын ажил, гал гарсан үед түүнийг унтраах хэрэгслийн хангамж, цахилгаан тоног төхөөрөмж дээр ажиллах үд мөрдөх аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг МУ-н “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Аж ахуй нэгж байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”, “Гал түймрийн аюулгүй байдалтай холбогдуулан гаргасан тушаал, шийдвэрийн дагуу зохион явуулна

Авто тээврийн осол: Машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, ажлын байрны үзлэг шалгалтыг байнга хийх. Ажилчдын аюулгүй ажиллагааны сургалтад тогтмол хамруулах. Уурхайн зам тээвэрт хурдны хязгаар тогтоож, тэмдэг тэмдэглэгээг сайн хийх, замын хөдөлгөөний аюулгүй дүрмийг чанд баримтлан ажиллах

Хүснэгт 12. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Түлшний агуулах, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	- Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	0.5	Жил бүр, жилд 2 удаа
	- Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	0.5	2024
	- Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулах	0.2	Жил бүр уурхай эхлэх үед
Хүчтэй салхи шуурганы улмаас тоос ихээр босч ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, тоосжилтоос үүсэх бусад нөлөөлөл	- Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох - Автомашинуудыг кабиныг битүүмжлэл сайтай болгох	-	Үйл ажиллагааны туршид
Хүчтэй аадар бороо, аянга цахилгааны улмаас ажлын байрны аюулгүй байдал, дэд бүтцийн байгууламж эвдэрч сүйдэх, цахилгаан тасрах, хүний амь нас, эрүүл мэнд хохирох	- Шаардлагатай газруудад аянга зайлуулагч суурилуулах	-	2024
	- Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед гадаах ажлыг түр зогсоох	-	Үйл ажиллагааны туршид
Ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	- Ажилчдыг ээлжид гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-	Өдөр бүр ээлжид гарахын өмнө
	- Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	1.0	Жил бүр, улиралд 1 удаа
	- Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг ажилчдын байр бүрд байрлуулах	Уурхайн зардалд орсон	Үйл ажиллагааны туршид
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургаалтанд хамруулах, - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах	-	Жил бүр
	- Жолооч бүрийг даатгалд хамруулах	Уурхайн зардлаас	Жил бүр 6 сараас өмнө
	- Машины кабин бүрд эмийн сан, галын хор байрлуулах		Уурхай эхлэхэд
Нийт зардал, сая.төг		2.2	

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Юбиксолюшн” ХХК-ийн “Цагаан чулуут хоолойн доод (ХШ-42-ХШ-50-ын хооронд)” хэсгийн алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээний локаль мониторингийн систем байгуулах нь зүйтэй. Мониторингийн цэгийг зөв сонгож, хугацаа, давтамж зэргийг нь оновчтой сонгож өгөх нь чухал юм. Тус төслийн орчимд явуулбал зохих экологийн хяналтын мониторингийн ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, мониторингийн ажлын давтамж, хэмжилт судалгааны ажлыг хариуцах мэргэжилтэн, мониторингийн үзүүлэлт зэргийг доорх хүснэгтэд тусган оруулж өгөв.

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших MV-021971 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Цагаан чулуут хоолойн доод (ХШ-42-ХШ-50-ын хооронд)” хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

2026 он

Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж, Хүнд металл тодорхойлох Агаар орчны бохирдол агаар дахь цацраг, дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил	Уурхай, Уурхайн ухаж ачих процессын үед, ажилчдын хотхон, уурхайн дотоод зам, баяжуулах үйлдвэр	8-р сард	5 цэгт жилд 1 удаа хэмжилт хийлгэнэ. (нэг цэгт 20 минут, автомат анализатораар хэмжилт хийхээр тооцсон)	100000	500.0		MNS 4585:2025 MNS 6063:2010 MNS 6768:2019 MNS 3113:1981 MNS 5885:2008 Агаарын тухай хууль 2012.05.17 Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль 2010.06.24
	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар) Цэвэр болон бохирын нуураас хүнд металлын шинжилгээ /As, U, Pb, W, Th, Sn, Nb, Se, Zn, Zr/	Худаг-1, Цэвэр болон бохирын нуураас-2,	8-р сард	Усны ерөнхий химийн шинжилгээ Хими бактериологийн бүрэн шинжилгээ 1 цэгээс 1 удаа	Усны ерөнхий химийн шинжилгээ нэгжийн үнэ 50.0 мян.төг *4*1 удаа=200.0 мян.төг Хими бактериологийн бүрэн шинжилгээ ний үнэ 100.0*1/ун дны усны худаг/ удаа=100.0	480.0		MNS /ISO/ 5667-11:2000 MNS 6148:2010 MNS 4943:2015 MNS 0900:2018 Усны тухай хууль 2012.05.17

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших MV-021971 тоот тусгай зөвшөөрлийн дугаар бүхий “Цагаан чулуут хоолойн доод (ХШ-42-ХШ-50-ын хооронд)” хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

2026 он

					мян.төг Хүнд металлын шинжилгээ ний үнэ 60.0 мян.төг Знуур*1уда а*180.0 мян.төг			
	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	Уурхайн шимт хөрсний овоолго, ахуйн бохир усны хаягдал орчимд, хотхон, засварын талбай	8-р сард	4 цэгт жилд 1 удаа	75000	300.0		MNS 5850 : 2019 MNS 3298 : 1991 MNS 5546 : 2005 MNS 3985 : 1987 MNS 2305 : 1995
	Орд орчмын ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа, амьтны зүйлийн бүрдэл, тархац	Тусгай зөвшөөрлийн талбай	8-р сард		-	1500.0		Байгалийн ургамлын тухай хууль Ургамал хамгааллыг тухай Амьтны тухай хууль, Ажиглах болон дээж талбайн тооллого Цэгэн ажиглалт, трансектын аргууд
Нийт зардал мян.төг		2780.0						

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажиллана.

Хүснэгт 14. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Усны нөөцийг үр ашигтай ашиглаагүйгээс газрын доорх усны нөөц, горимд өөрчлөлт орно.	Ус ашиглах дүгнэлт гаргуулан, холбогдох газраас ус ашиглах зөвшөөрөл авах	Гүний уснаас хангана	-	-	Усны тухай хууль
Ажилчдын мэдлэг чадвар дутмаг байдлаас ажлын доголдол гарах	Уурхайд ажиллаж байгаа ажиллагсдын тухайн ажлыг хийж гүйцэтгэх мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургалтад хамруулж байх	Жил бүр	2.0	Жил бүр	МУ-ын үндсэн хууль Хөдөлмөрийн тухай Эрүүл мэндийн тухай Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм
Уул уурхайн үйл ажиллагаанаас ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй	Ажлын байрны хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилчдыг илчлэг, витаминлаг хоол хүнсээр хангах	Бүх ажилчдыг	Үйл ажиллагааны зардал орсон	Өдөр бүр	Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм MNS 4990:2000 MNS 4968:2000 MNS 4994:2000
Нийт зардал, сая.төг			2.0		

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГЫН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ

Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Сумын иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.		9-р сард	Дотоод үйл ажиллагааны зардалд	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.	-
2		Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.		11 сарын 1-нд багтаан			-
3		Нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комисст хүлээлгэн өгөх.		10-р сараас 12-р сарын 1 нд багтаан			-
	Нийт	Дотоод үйл ажиллагааны зардалд орсон.					

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Хүснэгт 16. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	12500.0
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	10000.0
4	Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарих	2000.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	7700.0
6	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2200.0
8	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	500.0
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2780.0
10	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	2000.0
	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	39680.0

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нөхөн сэргээх арга хэмжээнд нийт 39.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Үүний 50 хувь 19.8 сая төгрөг байна. Бид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.